

**НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ**

Д/д	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл
1	<b>Нэр</b> Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр	Номоо гэлэн овогтой Загдаагийн Өнөржаргал
2	<b>Хүсэлт гаргагчийн хаяг</b> Иргэний үнэмлэхэд байгаа хаяг	
3	<b>Төрсөн огноо</b> Төрсөн газар	
4	<b>Боловсрол</b> Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургууль 2011-2014 он хууль зүйн магистр №20142593</li> <li>- Отгонтэнгэр Их Сургууль Хууль зүйн сургууль 2002-2005 он эрх зүйн бакалавр №200513021</li> <li>- МУИС-ын Хэл соёл, шинжлэлийн сургууль 1999-2002 он англи хэлний орчуулагч №72</li> </ul>
5	<b>Ажил эрхлэлт</b> Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албанд Ахлах референт 2011.11.11. №62</li> <li>- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албанд референт 2007.02.05. №05</li> <li>- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албанд мэргэжилтэн 2006.04.03. №05</li> </ul> <p>Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Тусгаар тогтнолын талбай Засгийн газрын XI байр, 5 дугаар давхар</p>
6	<b>Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал</b> Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ.	Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн
7	<b>Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил</b> Хүсэлт гарагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ. -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албанд ахлах референт 8 жил 6 сар</li> <li>- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албанд референт 4 жил 9 сар</li> <li>- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албанд мэргэжилтэн 10 сар</li> </ul> <p><b>Нийт ажилласан хугацаа 14 жил 1 сар (2006.04-2020.05.)</b></p> <p><b>(Эрх зүйч мэргэжлээр ажилласан ажлын байрны тодорхойлолт, ажил албан тушаалын тодорхойлолтыг хавсаргав)</b></p>

	барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.	
8	<b>Ёс зүй</b> Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно. -сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх; -сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх.	-
9	<b>Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар</b> Хүсэлт гарагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ. -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.	Комиссын Тамгын газрын даргаар ахлуулсан хуулийн төсөлд санал боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажилладаг бөгөөд энэ хүрээнд олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээг харьцуулан судлах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хуулийн зөрчлийг арилгах, хүний эрхийн стандарт хэм хэмжээнд нийцүүлэх, хуулиар тогтоосон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрх зүйн байдлыг дордуулахгүй байх үндэслэл хэрэгцээ шаардлагыг судлах, хуулийн төсөлд хүргүүлэх саналын томъёоллыг эцэслэн боловсруулж байна. Мөн хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хийсэн бодлогын судалгаа шинжилгээний ажлын тайланг эцэслэн боловсруулах, цаашид авах арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулах, холбогдох яамнаас байгуулагдсан ажлын хэсэг ажиллах, хууль санаачлагчдын зохион байгуулсан хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцох зэргээр ажиллаж байна. Мөн Хүний эрхийн Үндэсний Комиссоос аймаг орон нутагт зохион байгуулдаг “Хүний эрхийн нээлттэй өдөр” арга хэмжээний үеэр аймгийн Засаг даргын захирамж, ИТХ-ын тогтоол шийдвэр, нийтээр мөрдөх хэм хэмжээ тогтоосон захиргааны хэм хэмжээний актад 3 жилийн байдлаар судалж, дүн шинжилгээ хийн холбогдох саналаа гарган ажиллаж байна.  <b>Нэг.</b> Комисст 2013 оноос өнөөг хүртэл хугацаанд судалгаа, бодлого дүн шинжилгээ хариуцсан ахлах референтээр сонгогдон ажиллахдаа хууль тогтоомж, захиргааны шийдвэр хүний эрхийн үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж, санал гаргах ажлыг шинэ шатанд гаргах, сайжруулах зорилгоор УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төсөл болон хууль тогтоомжийн төсөлд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх, хууль санаачлагчид санал боловсруулж хүргүүлэх ажлыг тогтмолжуулан хариуцан байна. Комиссын хууль тогтоомжийн төслийн судлах, ажлын хэсгээс 2013 оноос өнөөдрийг хүртэл 120 хуулийн төсөл, УИХ, Засгийн газрын тогтоолын төсөлд 740 гаруй саналын томъёоллыг нэгтгэн боловсруулж танилцуулан, хууль санаачлагчдад хүргүүлжээ. Энэ хүрээнд 40 хуулийн төсөл, УИХ, Засгийн газрын тогтоолын төслийг дангаараа судалж

		<p>холбогдох саналаа гаргажээ.</p> <p>Тухайлбал, 2016 онд тахарын албаны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 22 дүрэм журам хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхэд харьцуулсан дүн шинжилгээ хийж нийт 25 санал зөвлөмжийг дэвшүүлэн, Комиссын удирдлагад танилцуулснаар Хууль зүйн сайдад холбогдох журмуудад өөрчлөлт оруулах 16 саналыг томъёолон хүргүүлсэн байна.</p> <p><b>(УИХ-д өргөн барьсан хуулийн төсөл, хууль тогтоомж болон дүрэм журмын төсөлд Комиссоос хүргүүлсэн саналын томъёолол боловсруулсан жагсаалтыг Хавсралт: 1 үзнэ үү)</b></p> <p>Мөн батлагдсан хуулиудад Комиссын санал тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийх зэргээр ажиллаж байна. Тухайлбал, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүдэд Комиссоос хүргүүлсэн санал холбогдох хуулийн төслүүдэд тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийж үзэхэд 2013-2016 онд Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслүүдэд 9 удаа 184 санал гаргасны 90 буюу 48 хувь хуулийн төслүүдэд тусгагдаж, харин 94 буюу 52 хувь нь тусгагдаагүй байна.</p> <p><b>(Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслүүдэд Комиссоос 2013-2016 онд өгсөн саналын томъёолол тусгагдсан эсэхэд хийсэн дүн шинжилгээний мэдээг Хавсралт: 2 үзнэ үү)</b></p> <p><b>Хоёр.</b> Комисст хяналт шалгалт хийх, иргэдийн өргөдөл, гомдлыг шалгах, хууль зүйн зөвлөгөө өгөх, судалгаа дүн шинжилгээ ажлын хүрээнд хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд илэрсэн зөрчлийг арилгуулахаар 45 удаа Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг боловсруулж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлсэн байна.</p> <p>Тухайлбал, 2018 онд нийтээр дагаж мөрдүүлэхээр НИТХ-аас баталсан, мөн түүний Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан, Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан захиргааны хэм хэмжээний 90 актыг дангаараа судалж, дүн шинжилгээ хийв. Энэ хүрээнд ИТХ болон түүний Тэргүүлэгчдийн тогтоолоор нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан захиргааны хэм хэмжээний актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдөж байгаа нь иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй, тэдэнд чирэгдэлтэй, хүндрэлтэй нөхцөл байдал үүсч, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт хангагдаж чадахгүй байв.</p> <p>НИТХ болон түүний Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжаар баталсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрт хийсэн дүн шинжилгээний хүрээнд хүний эрхэд суурилсан захиргааны хэм хэмжээний актыг боловсруулах, түүний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж гарган Комиссын удирдлагад танилцуулсны дагуу зөвлөмжийг боловсруулан НИТХ-ын даргад хүргүүлсэн байна.</p> <p><b>(Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг боловсруулж, холбогдох</b></p>
--	--	--

байгууллагуудад хүргүүлсэн жагсаалтыг Хавсралт: 3-аас үзнэ үү. Мөн “Хүний эрх” онол арга зүйн сэтгүүлийн 2018/02 дугаарт нийтлэл болгон хэвлүүлсэн.)

**Гурав.** 2019 онд хүний эрхийн зорилтот бүлгийн нэг болох малчид тэр дундаа алслагдсан аймаг, сум дахь малчин эмэгтэйчүүдийн өнөөгийн нөхцөл байдал, тэдгээрийн хүчирхийллээс ангид байх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн хэрэгжилтийн зарим асуудлыг судалж, үнэлэх зорилгоор “**Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилт: Хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал**” судалгааг гүйцэтгэж, тайланг эцэслэн боловсруулав. Судалгааны хүрээнд кейс тохиолдлыг шинжлэн судлах, санал асуулгад SPSS анализ хийх, экспертийн, ганцаарчилсан, бүлгийн ярилцлага болон хуулиар үүрэг хүлээсэн холбогдох төрийн байгууллагуудын статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх, олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээг харьцуулан судалж, үнэлэхийн сацуу тэдгээрийн гэрлэлт, боловсрол, амьжиргаа, орлогын эх үүсвэр, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой хүндрэл бэрхшээл, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байдал, туслах малчны ажил, хөдөлмөртэй холбоотой зарим асуудалд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний санал зөвлөмжийг дэвшүүлсэн болно. Судалгааны үр дүнг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дахь илтгэлд тусгаж, малчин эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр 13 саналыг гарган УИХ-д хүргүүлсэн байна.

“**Малчин эмэгтэйчүүдийн хүний эрхийн хэрэгжилт: Хүчирхийллээс ангид байх эрх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийн зарим асуудал**” судалгааны тайланг монгол, англи хэлнээ гаргасан. Үзэх холбоос: <https://lib4u.net/opac.php/ebook/?id=168&lib=nhrc>  
Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дахь илтгэлийг үзэх холбоос: <https://lib4u.net/opac.php/ebook/?id=184&lib=nhrc>

**Дөрөв.** 2018-2019 онд “**Албан болон насан туршийн боловсролын тогтолцоон дахь Хүний эрхийн боловсролын өнөөгийн нөхцөл байдлын зураглал хийх**” болон “**Хүний эрхийн боловсролын бодлого, төлөвлөлтөд хийсэн дүн шинжилгээ**” сэдвийн хүрээнд хоёр судалгаа, дүн шинжилгээний ажлыг хийж, Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын өнөөгийн зураглал, хэрэгжилтийн байдал болон хүний эрхийн боловсролын агуулга холбогдох хууль тогтоомж болон хөтөлбөрт тусгагдсан байгааг харьцуулан судалж тайланг эцэслэн боловсруулав. Эдгээр судалгаа, дүн шинжилгээний ажлыг хийхдээ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн “Хүний эрхийн боловсрол-2020” олон улсын иргэний нийгмийн эвслээс боловсруулсан хүний эрхийн боловсрол, сургалтын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг ашиглан Монгол Улсын боловсролын салбарын 20 гаруй хууль, дүрэм журам, хөтөлбөрийг харьцуулан судалж, хүний эрхийн боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус, олон улсын 30 гаруй байгууллагын тайлан, мэдээллийн эх сурвалжид үндэслэн

боловсруулав. Дүн шинжилгээгээр Монгол Улс албан болон албан бус боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын талаарх бодлого, түүний хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний санал зөвлөмжийг дэвшүүлсэн болно. Уг ажлын үр дүнг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлд тусган, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан Хүний эрхийн боловсролын гурван Дэлхийн хөтөлбөр түүний үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулж төрөөс хүний эрхийн боловсролын талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх, их, дээд сургуулиудын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд тусгах, хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудын санаачилгыг дэмжин урамшуулах, хамтран ажиллах зэрэг асуудлаар УИХ-аар шийдвэр гаргуулахаар санал хүргүүлэв.

**“Хүний эрхийн боловсролын бодлого, төлөвлөлтөд хийсэн дүн шинжилгээ”-ний тайланг үзэх холбоос:**

<https://lib4u.net/opac.php/ebook/?id=165&lib=nhrc>

**Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг үзэх холбоос:** <https://lib4u.net/opac.php/ebook/?id=140&lib=nhrc>

**Тав.** 2017 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Европын Холбооны дэмжлэг, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын техникийн зөвлөмжийн тусламжтайгаар хувийн хэвшлийн салбараас худалдаа үйлчилгээ, ноос ноолуурын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн хэрэгжилтийн асуудлыг анх удаагаа цогцоор нь судлах бодлогын судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Энэ хүрээнд Монгол Улсын нэгдэн орсон ОУХБ-ын суурь найман гэрээ конвенцын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээний харьцуулалтыг судалж, тайланг эцэслэн боловсруулав. Судалгааны үр дүнд тулгуурлан УИХ, Засгийн газар, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллагуудад тэр дундаа Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэлтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох, бодлого, үйл ажиллагаа зохицуулалт, зохион байгуулалтын чиглэлээр авах арга хэмжээний 41 санал зөвлөмжийг дэвшүүлсэн бөгөөд судалгааны тайланг товхимол болгон монгол, англи хэлнээ хэвлүүлж, нийтийн хүртээл болгов. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд судалгаагаар дэвшүүлсэн санал зөвлөмж болон Комиссын ажлын хэсгээс гарсан саналын томъёоллыг нэгтгэн боловсруулж, 3 удаа санал хүргүүлсэн байна. **“Жижиг дунд үйлдвэр дэх хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал: Худалаа үйлчилгээ, ноос ноолуурын салбар”** судалгааны тайланг үзэх холбоос:

<https://lib4u.net/opac.php/ebook/?id=69&lib=nhrc>

Судалгааны тайланг CD хуулбарлав.

Судалгааны ажлыг Монгол Улсын хэмжээнд судлахаар ОУХБ-д төслийн саналыг миний бие боловсруулж, хүргүүлсний үндсэн дээр дэмжигдэж хийсэн болно. Төслийн үйл ажиллагаа үр дүнгийн талаарх үзэх холбоос: [https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms\\_672753.pdf?fbclid=IwAR2XnnN3R1BRNBAVtmbmc4bgc4iS7evmEniNvS-P2CUBsM\\_O-62R2jhmrz8](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---asia/---ro-bangkok/---ilo-beijing/documents/publication/wcms_672753.pdf?fbclid=IwAR2XnnN3R1BRNBAVtmbmc4bgc4iS7evmEniNvS-P2CUBsM_O-62R2jhmrz8).

[https://www.ilo.org/beijing/information-resources/public-information/press-releases/WCMS\\_612466/lang--en/index.htm](https://www.ilo.org/beijing/information-resources/public-information/press-releases/WCMS_612466/lang--en/index.htm)

Үүний зэрэгцээ Комисст сонгууль бүрийн дараа төрийн албан хаагчдын гомдол ихээр ирэх болсон тул төрийн албаны шинэтгэл, УИХ-аар Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж байгаатай холбоотой 2017 онд төрийн албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийв. Энэ хүрээнд төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, сонгон шалгаруулалт, өргөдөл гомдол, маргаан шийдвэрлэлтийн байдал, төрийн албанаас үндэслэлгүйгээр халагдсаныг тогтоосон шүүхийн шийдвэр биелэхгүй байгаагаас тухайн албан хаагчид учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зарим асуудлыг Захиргааны хэргийн шүүхийн төрийн алба хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн зарим шийдвэр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шүүхийн шийдвэрийн биелэлтийн мэдээ, Төрийн албаны зөвлөл болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн зэрэг байгууллагын тайлан, судалгаа, статистик мэдээллийн харьцуулан судлав. Ийнхүү Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлд Хөдөлмөрлөх эрхийн зарим асуудал сэдвийн хүрээнд Төрийн албан хаагчид болон хувийн хэвшилд ажиллагсдын хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн байдлыг үнэлж боловсруулав. **Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэлийг** үзэх холбоос: <https://lib4u.net/opac.php/ebook/?id=71&lib=nhrс>

**Зургаа.** 2017 онд гэр хорооллын газрыг дахин төлөвлөж барилгажуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих зэрэг үйл ажиллагааны хүрээнд хүн бүрийн орон байртай байх эрхийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор Монгол Улсын эрх зүйн өнөөгийн зохицуулалтыг харьцуулж, холбогдох яам, нийслэлийн төр захиргааны байгууллага, олон улсын байгууллагын тайлан, судалгаа, статистик мэдээлэл болон иргэдийн гаргасан гомдол, санал, кейс тохиолдлыг судалж, Улаанбаатар хотын төлөвлөлтийн төсөл хөтөлбөрийн хүрээнд тулгамдаж буй хүний эрхийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийв. Дүн шинжилгээгээр Хот төлөвлөлтийн талаарх төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоо хангалтгүй, Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын гэрээгээр баталгаажсан хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцэхгүйн зэрэгцээ ялангуяа хот, суурин газрыг дахин хөгжүүлэх харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, түүнийг даган гарсан дүрэм журам нь тухайн нөхцөл байдал, үйл явцыг зохион байгуулах, зохицуулах, хянаж чадахгүй байгаагаас иргэдийн орон байртай байх эрхийг бүрэн хамгаалж чадахгүй байгаа асуудлаар санал зөвлөмж гаргасан болно. Үр дүнг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 2017 дахь илтгэлд тусгав. **Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэлийг** үзэх холбоос:

<https://lib4u.net/opac.php/ebook/?id=187&lib=nhrс>

2020 онд Монголын Эмнести Интернэшнл, Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш нар, хуульчидтай хамтран хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл

ажиллагааны хүрээнд “Орон байртай байх эрхийг хангаж, хамгаалах эрх зүйн орчин, хэрэгжилт” судалгааг газар үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх асуудлын хүрээнд олон улсын сайн туршлага, газрыг орон сууцаар солих, орон сууцыг орон сууцаар солих эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийг судлах ажлыг эхлүүлээд байна.

**Долоо.** 2015 онд Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох эрүүгийн хэрэг үүсгэснээс эхлэн шүүхэд хэргийг шийдвэрлэх хүртэл хугацаанд өмгөөлөгчөөс үзүүлж буй хууль зүйн туслалцаа нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шуурхай, бүрэн, тууштай байдал, нууцыг чанд хадгалах зарчимд нийцэж байгаа эсэхийг судлах, өнөөгийн практик, нөхцөл байдлыг үнэлж, дүгнэлт хийх, хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилтийг хангахад тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, санал зөвлөмж дэвшүүлэх зорилгоор **“Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт”** бодлогын судалгааг гүйцэтгэв. Судалгааны хүрээнд хэрэглэгдэхүүн боловсруулах, олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах, цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, өмгөөлөгчийн оролцоо, эрх үүрэг, хариуцлагыг нь нэмэгдүүлэх чиглэлээр дүгнэлт, саналыг гарган, тайланг эцэслэн боловсруулав. Мөн холбогдох талуудыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлд нэг бүлэг болж тусгав. Илтгэл болон судалгаагаар дэвшүүлсэн саналыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд саналаа гарган хүргүүлсэн байна.

**“Цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хууль зүйн туслалцаа авах эрхийн хэрэгжилт”** судалгааны тайланг үзэх холбоос: <https://lib4u.net/opac.php/ebook/?id=178&lib=nhrc> **Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлийг** үзэх холбоос: <https://lib4u.net/opac.php/ebook/?id=20&lib=nhrc>

**Найм.** Комисст ахмад настны эрх, хамгааллын асуудлаар мэргэшин судалж ирсэн бөгөөд 2015 онд ахмад настны эрхийг хамгаалах чиглэлээр олон улсын туршлага, тухайн үеийн Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн хэрэгжилт, ахмад настны эрхийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох, ахмад настны эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор **“Ахмад настны нийгмийн хамгаалал ба хүний эрхийн асуудал”** бодлогын судалгааг гүйцэтгэж, тайланг эцэслэн боловсруулав. Судалгааны үр дүнг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлд тусгаж, илтгэлээр дэвшүүлсэн санал 2017 оны Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан төдийгүй судалгааны хүрээнд гаргасан ахмад настан болсныхоо төлөө онцгой ач холбогдолтой эрх, хамгааллын олон улсын зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн хуульчилсан нь чухал ач холбогдолтой болсон юм.

**“Ахмад настны нийгмийн хамгаалал ба хүний эрхийн асуудал”** судалгааны тайланг үзэх холбоос: <https://lib4u.net/ebook/?lib=nhrc&id=157> **Монгол Улс дахь хүний эрх, эрх**

		<p><b>чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэлийг үзэх холбоос:</b>  <a href="https://lib4u.net/opac.php/ebook/?id=20&amp;lib=nhrс">https://lib4u.net/opac.php/ebook/?id=20&amp;lib=nhrс</a></p> <p>Судалгааны үр дүнг танилцуулах, ахмад настны эрх хамгааллын чиглэлээр нөлөөллийн ажлыг зохион байгуулахад хамтран ажиллаж 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр Гадаад харилцааны яаманд зохион байгуулсан “Ахмад настны хүний эрхийг баталгаажуулъя” Үндэсний 3 талт хэлэлцүүлэгт судалгааны үр дүнг танилцуулагдсан болно. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2010 оны 65/182 дугаар тогтоолоор ахмад настны эрхийн асуудлаар НҮБ-ын конвенц боловсруулах Нээлттэй ажлын хэсэгт дотоодын хуулийн үзэл баримтлалтай уялдуулан санал өгөх, тус конвенцыг батлахыг дэмжих зэрэг асуудлаар оролцогч талууд байр сууриа илэрхийлсэн билээ. Тус хэлэлцүүлэг Комиссын даргын хэлэх үгийг миний бие боловсруулав. Мөн 2019 онд Хүний эрхийн дээд комиссарын газраас ирүүлсэн асуулгын хүрээнд үндэсний хууль тогтоомж болон бодлогын хүрээнд ахмад настны хөдөлмөрлөх эрх ба хөдөлмөрийн зах зээлд гарах боломж, хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдөхүйц, чанартай байдал, тэгш байдал ба үл ялгаварлан гадуурхалт, боловсрол, сургалт, насан туршийн боловсрол ба чадавхи бий болгох, нийгмийн халамж болон нийгмийн хамгаалал байдлын талаар мэдээлэл бэлтгэх хүргүүлсэн байна.</p> <p>Ахмад настны эрх хамгааллын чиглэлээр ХНХЯ-наас байгуулагдсан 2 ажлын хэсэгт ажиллалаа. ХНХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/132 дугаар тушаалаар байгуулсан “Ахмад настны хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийн ажлын хэсэгт ажиллаж, олон удаагийн уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд хөтөлбөр Засгийн газрын 2019 оны 389 дүгээр тогтоолоор батлагдлаа.</p> <p>Монгол Улсад ахмад настны эрх хамгааллын хүрээнд урт хугацааны тусламж үйлчилгээ үйл ажиллагааг нэгдсэн бодлого, төлөвлөлт, зохицуулалтаар салбар дундын уялдаа холбоог ханган хэрэгжүүлэх асуудал тулгамдаж байгаа билээ. 2017 онд Азийн хөгжлийн банкны “Бүсийн техник тусалцааны төсөл 9111: Хөгжиж буй гишүүн орнуудын ахмадын тусламж үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд Индонез, Монгол, Шри-Ланк, Тайланд, Тонга, Вьетнам гэсэн 6 улсад урт хугацааны тусламж үйлчилгээний нөхцөл байдлын тодорхойлж, шинжилгээ хийхээр сонгогдсон. Монгол Улс дахь урт хугацааны тусламж үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын талаарх судалгаа шинжилгээний хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/251 дүгээр тушаалаар Ахмад настны урт хугацааны тусламж үйлчилгээний стратеги төлөвлөгөө боловсруулах салбар дундын ажлын хэсэг байгуулагдаж, тус ажлын хэсэгт ажиллав. Ажлын хэсэг уулзалт, сургалтын үр дүнд Азийн хөгжлийн банкны “Бүсийн Техник тусалцааны төсөл 9111: Хөгжиж буй гишүүн орнуудын ахмадын тусламж үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх нь” төсөл хэрэгжүүлэгчдийн арга зүйн дэмжлэгтэйгээр “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний үйл ажиллагааны төлөвлөгөө 2020-2024”-г боловсруулахад оролцов. Төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлуулж, цаашид хэрэгжүүлэхэд шаардагдах</p>
--	--	--



		<p>зардлыг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр болсон байна.</p> <p><b>Ес.</b> 2014 онд үйлдвэрчний эвлэлийн байгууллагын өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагааг хүний эрхийг хамгаалагчийн эрхийг хамгаалах тогтолцооны олон улсын нийтлэг чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох чиглэлээр санал зөвлөмж гаргах зорилгоор <b>“Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа”</b> бодлогын судалгааг гүйцэтгэв. Судалгааны түүвэрт 21 аймгийн 3662 үйлдвэрчний эвлэлийн гишүүн, идэвхтэн сонгуультан хамрагдсан бөгөөд судалгаагаар үйлдвэрчний эвлэлийн байгууллагын хөдөлмөрийн харилцаатай холбоотой аливаа үйл ажиллагаанд оролцох хэлбэр, эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчиж буй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг хууль тогтоомжид тодорхой заагаагүйгээс уг эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх нэг шалтгаан болж байгаа зэргийг SPSS анализ, кейс анализ, хууль тогтоомжийн харьцуулалтад үндэслэн тодорхойлсон юм. Судалгааны үр дүнгээр 1991 оны Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийг шинэчлэн найруулахдаа эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх талуудын эрх, үүрэг, хариуцлага болон Үйлдвэрчний эвлэлийн гишүүн, сонгуульт ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлох талаар санал зөвлөмж дэвшүүлж, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлд тусгасан болно.</p> <p><b>“Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа”</b> судалгааг үзэх холбоос: <a href="https://lib4u.net/opac.php/ebook/?id=158&amp;lib=nhrc">https://lib4u.net/opac.php/ebook/?id=158&amp;lib=nhrc</a> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлийн үзэх холбоос: <a href="https://lib4u.net/opac.php/ebook/?id=182&amp;lib=nhrc">https://lib4u.net/opac.php/ebook/?id=182&amp;lib=nhrc</a></p> <p>Үүний зэрэгцээ “Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалагчдын эрх, эрхийн хэрэгжилтийн төлөв байдал” судалгаанд мэргэжлийн үйл ажиллагаагаар хүний эрхийг хамгаалж буй шүүгч, прокурор, цагдаагийн байгууллагын албан хаагч, өмгөөлөгч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, иргэний нийгмийн байгууллагын ажилтан, хүний эрхийг хамгаалагч, идэвхтэн зэрэг 1375 оролцогчийг хамруулан нөхцөл байдлыг тодорхойлон, олон улсын хэм хэмжээ болон үндэсний хууль тогтоомжийн харьцуулалт, SPSS анализ, кейс анализ зэрэгт үндэслэн цаашид авах арга хэмжээний санал зөвлөмжийг гаргасан юм. Судалгааны үр дүнд хүний эрхийг хангаж, хамгаалах хууль тогтоомжийг батлан гаргаж байгаа ч хүний эрхийг хамгаалагчийн эрх үүрэг, үйл ажиллагааг зохицуулсан бие даасан хууль байхгүй, мөн “хүний эрхийг хамгаалагч” гэсэн ойлголт, нэр томъёо өнөөдөр үйлчилж буй хууль тогтоомжид тусгагдаагүй байна. Түүнчлэн хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсны төлөө тухайн байгууллага, иргэн, ажилтны эрх зөрчигдсөн тохиолдолд түүнийг хамгаалах эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй, зөвхөн салбарын хуулиар зохицуулж байгаа тул Хүний эрхийн хамгаалагчийн тухай бие даасан хуулийн төслийг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1998 оны A/RES/53/144 тогтоолоор баталсан “Хүний эрхийг хамгаалагчийн тунхаглал”-ын үзэл санаа, агуулгад нийцүүлэх боловсруулах талаар</p>
--	--	--

		<p>санал зөвлөмж гаргасан Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлд тусгасан болно.</p> <p>Хүний эрхийн хамгаалагчийн судалгааны үр дүнгээр хүний эрхийг хамгаалагчийн аюулгүй байдлыг хангах, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хүний эрхийг хангаж, хамгаалахад оруулж буй хувь нэмрийг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг үйл ажиллагаандаа хэвшүүлж ажиллах талаар Комиссын гишүүний зөвлөмжийг УЕПГ, УДШ, ШЕЗ, ЦЕГ-т тус тус хүргүүлсэн байна. Хүний эрхийн хамгаалагчийн тухай хуулийг УИХ-д өргөн барьсан байна. <b>Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн жагсаалтыг Хавсралт: 3-аас үзнэ үү.</b></p> <p><b>“Монгол Улс дахь хүний эрхийг хамгаалагчдын эрх, эрхийн хэрэгжилтийн төлөв байдал”</b> судалгааны тайланг үзэх холбоос:  <a href="https://lib4u.net/opac.php/ebook/?id=159&amp;lib=nhrc">https://lib4u.net/opac.php/ebook/?id=159&amp;lib=nhrc</a> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлийн үзэх холбоос:  <a href="https://lib4u.net/opac.php/ebook/?id=182&amp;lib=nhrc">https://lib4u.net/opac.php/ebook/?id=182&amp;lib=nhrc</a></p> <p><b>Арав.</b> 2012 онд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй шашны боловсрол эзэмшүүлэх сургууль, сүм, хийдэд шавилан суралцаж буй хүүхдийн сурч боловсрох, эрүүл, аюулгүй байх, хөгжих, оролцох, хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг үнэлж, тогтоогдсон нөхцөл байдалд үндэслэн холбогдох байгууллагуудад санал, зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангуулах зорилгоор нийслэлийн найман дүүргийн 26, 12 аймгийн буддын 28 сүм хийд болон христийн шашны 7, исламын шашны 1 байгууллагад хяналт, үнэлгээ хийж, санал асуулгад буддын сүм хийдэд шавилан суралцаж буй 290 хүүхдийг хамруулав. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудтай хамтран уг хяналт үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд анх удаагаа шашны байгууллагуудад хийж байгаагаараа онцлог байв. Хяналт үнэлгээгээр сүм хийдэд шавилан суугаа хүүхдийн асуудал төрийн холбогдох байгууллагын анхаарлын гадна үлдсэн хийгээд шашны байгууллага зөвхөн шашны ном заахыг урьтал болгодог зэргээс шалтгаалан эдгээр хүүхэд орчин цагийн шаардлагад нийцсэн боловсрол эзэмшиж чадахгүйн дээр тэдний зарим эрх зөрчигдөхөд хүрч байгааг тогтоож, сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүдийг ерөнхий боловсролд тэгш хамруулан сургах хувилбар, загварыг тодорхойлох, хүүхдийн суурь боловсрол олгоход шашны байгууллагын зүгээс ямар үүрэг хүлээх, төрийн зүгээс хэрхэн дэмжих, хэрхэн хариуцлага тооцох талаар нарийвчлан зохицуулах, шашны сургалтын стандарт, сургууль завсардалт, шашны байгууллагуудын боловсон хүчний хүний эрх, хүүхдийн эрхийг мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зэрэг хүүхдийн эрх, хамгаалах чиглэлээр 20 санал санал зөвлөмжийг дэвшүүлсэн болно. <b>“Шашны сургууль, сүм хийдэд шавилан суралцаж буй хүүхдийн эрхийн нөхцөл байдалд хийсэн хяналт, үнэлгээний тайлан”</b>-г нэгтгэн боловсруулж, үр дүнг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэлд тусгаж, сүм хийдэд шавилан суугаад суурь боловсрол давхар эзэмших боломжгүй байгааг харгалзан шашны сургалттай ерөнхий боловсролын сургуулийг үндэсний хэмжээнд бүсчлэн байгуулах талаар УИХ-аар шийдвэр гаргуулахаар саналаа хүргүүлсэн</p>
--	--	---

		болно. (Холбогдож тодруулах: НҮБ-ын суурийн төлөөлөгчийн газарт шинжээч Б.Болорсайхан Утас:9979-3999; “Бүх нийт боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн зохицуулагч Д.Тунгалаг Утас: 9912-9020) Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэлийг үзэх холбоос: <a href="https://lib4u.net/opac.php/ebook/?id=18&amp;lib=nhrc">https://lib4u.net/opac.php/ebook/?id=18&amp;lib=nhrc</a>
10	<b>Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил</b> Хүсэлт гарагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: -албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа; -ажлын байрны тодорхойлолт; -удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл.	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албанд ахлах референтээр 8 жил 6 сар</li> <li>- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албанд референтээр 4 жил 9 сар</li> <li>- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Ажлын албанд мэргэжилтнээр 10 сар</li> </ul> <b>Нийт ажилласан хугацаа 14 жил 1 сар (2006.04-2020.05.)</b>
11	<b>Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал</b> Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ: -үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа; -үйл ажиллагааны гол агуулга; -үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ; -үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл; -хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар.	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, урлагийн соёлын төрлүүдээр дамжуулан хүний эрхийн боловсрол, соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах, байгаль орчин, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага хамт олон, түүний дотор төрийн бус байгууллага, идэвхтэн сонгуультаан, сэтгүүлчид, иргэдийг дэмжин хамтран ажиллах, ном товхимол гарын гарын авлага, модулийг бэлтгэж, хэвлүүлэх, мөн байгаль орчин, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлыг бүх нийтийн үйл хэрэг болгох чиглэлээр нөлөөллийн олон талт үйл ажиллагаа, кампанит ажлуудад оролцож байна. <b>Нэг.</b> 2019-2020 онд Албадан хөдөлмөр, ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах ерөнхий зарчмын талаар сэтгүүлчдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны төслийн саналыг боловсруулж, ОУХБ-д хүргүүлсэн бөгөөд уг төслийн санал дэмжигдсэн билээ. Энэ хүрээнд “Албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах талаар сурвалжлах нь” сэтгүүлчдэд зориулсан сургалтын гарын авлагын Монгол Улс жишээн дээр гаргах хувилбарыг боловсруулахад олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтын харьцуулалтын мэдээллийг бэлтгэх, хянах, хэвлүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэлээ. Гарын авлага монгол англи хэлнээ хэвлүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд сэтгүүлчдэд зориулсан олон жишигт нийцсэн хувилбар болж байгаагаараа онцлог байна. Гарын авлагад олон улсын болон үндэсний зөвлөх 2 мэргэжлийн сэтгүүл зүйн багш нар хамтран ажилласан бөгөөд үндэсний болон бусад улс орнуудад гарч байгаа кейс тохиолдлыг судалж үнэлэн гарын авлагад тусгав.

**Хоёр.** 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулагдсан “Эко эмэгтэйчүүдийн анхдугаар чуулган”-ыг үйл ажиллагааг дэмжиж, бэлтгэл ажлыг хангахад биечлэн оролцож хамтран ажиллав. Чуулганд үндсэн илтгэгчээр оролцож “Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх: Нийслэлийн хот төлөвлөлттэй холбоотой хүний эрхийн зарим асуудал” сэдвээр илтгэл тавьж, илтгэлээрээ Улаанбаатар хотын усны бохирдол болон дахин төлөвлөлт, уул уурхай, гадаргын усны хомсдолтой холбоотой хүний эрхийн зөрчил, тулгамдсан асуудал, Комиссын илтгэлээр УИХ-д шийдвэр гаргуулахаар хүргүүлсэн саналыг танилцуулав. Тус чуулга уулзалтад амьдрал, ажил үйлс, бизнесээ эко чиглэлд хандуулдаг 100 орчим эмэгтэйчүүд оролцож олон санал санаачилга гаргасан. Энэхүү чуулганыг жил бүр уламжлал болгон зохион байгуулах төдийгүй цаашид Ази номхон далайн бүс нутгийн эко эмэгтэйчүүдийн чуулга уулзалт болгохоор зорьж байгаа бөгөөд уг ажлыг санаачилсан “Түгээмэл Эрх-Хөгжил” ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллаж байна.

Эко эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад тавигдсан илтгэлүүд эмхэтгэлийг үзэх холбоос: <https://lib4u.net/opac.php/ebook/?id=185&lib=nhrc>

**(Холбогдож тодруулах: “Түгээмэл Эрх-Хөгжил” Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн дарга Т.Саруул, Утас: 9908-8306)**

**Гурав.** 2020 оны “Эко эмэгтэйчүүдийн хоёрдугаар чуулган”-ы бэлтгэл ажлыг хангахад биечлэн оролцож байна. Энэ хүрээнд Улаанбаатар хотын хөрс, хөрсний усыг хамгаалах, агаарын бохирдол, тоосжилтийг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор “Нэг хашаа нэг мод” төслийн иргэдэд зориулсан суулгац суулгах, арчлах аргачлалыг танилцуулах сургалт хийх, зөвлөгөө өгөх зэргээр зохион байгуулалтын ажилд хамтран оролцож байна. Төслөөр нийт 1000 хашаанд мод тарихаар төлөвлөн уг ажлыг хэрэгжүүлэн төсөл боловсруулах ажилд холбогдох саналаа гарган Эко соёл сангийнхантай хамтран ажиллаж байна. 2020 оны хаврын тариалалтад Баянзүрх дүүргийн 19, 22 дугаар хорооны 300 хашааны өрхүүд эхний ээлжинд хамруулах графикайн дагуу 2020 оны 5 дугаар сарын 8, 10-ны өдрүүдэд 14 айлын хашаанд, 1 худаг, 1 хүүхдийн төв нийт 16 газарт 100 хайлаас, 25 чацарганы суулгац тарив. Төсөлд хамрагдаж байгаа айлуудын мод услах усны асуудлыг худагтай гэрээлүүлэн шийдэхийн сацуу борооны ус тосох замаар усалгааг хийх, усалгааны хугацааны зааварчилгаа өгч, онлайн апплейшн ашиглан мод тарих, модны арчлалт, хамгаалалтыг хэрхэн хийх талаар мэргэжлийн багаас өдөр тутам зөвлөгөө авах боломжийг бүрдүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөж байгаагаараа онцлог юм.

**(Дөрөв.** Монгол орны цэвэр усны нөөцийн 70 хувь, дэлхийн цэвэр усны нөөцийн 0.4-1 хувийг дангаараа бүрдүүлдэг Хөвсгөл нуурыг НҮБ-ын ЮНЕСКО-гийн дэлхийн байгалийн өвд бүртгүүлэх ажлыг сурталчлан, дэмжих зорилготой “Далай Ээж” Эко-Соёлын Аян-2019 олон улсын арга хэмжээг байгаль хамгаалал, хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран 14 хоногийн туршид зохион байгуулахад хамтран ажиллав.

Энэ хүрээнд Эко соёлын аянд оролцсон 9 орны 50 гаруй уран бүтээлчид, хөгжимчид, дуучид, зураачид, сэтгүүлч, хуульчид, байгаль орчны идэвхтэн судлаачдын мэдээллийг

		<p>нэгтгэсэн үйл ажиллагааны танилцуулга мэдээллийг англи монгол хэлээр бэлтгэхэд оролцлоо.</p> <p>2019 оны 7 дугаар сарын 8-ны өдөр “Усны эрх-хүний эрх: Хөвсгөл нуурын хамгаалал” олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавигдах “Хүний эрх ба Усны эрх” илтгэлийг боловсруулж, усаар хангагдах эрх, ус хамгааллын олон улсын болон үндэсний бодлого үйл ажиллагаа, Хөвсгөл нуурын цэвэр усны эко системийн хамгаалалт болон хүрээлэн буй орчин хүний эрх, тээвэр, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцүүлэв. Илтгэлийг <a href="http://www.nhrm.gov.mn">www.nhrm.gov.mn</a> цахим сайтаас үзнэ үү.</p> <p>2019 оны 7 дугаар сарын 9-ний өдөр “Далай ээж” олон улсын хөгжмийн үдэш, уран зургийн цомог үзэсгэлэн арга хэмжээгээр урлаг соёлоор хүний эрх-усны эрх, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалахын ач холбогдлыг таниулах сурталчлах ажлыг зохион байгуулав.</p> <p>Тус аяны хүрээнд Хөвсгөл аймаг Хатгал тосгоны дунд сургууль болон Соёлын төвийг зурж, чимэглэх, Хатгал тосгоны Хөвсгөл далайн боомт болон Соёлын төвд зохион байгуулах урлаг соёлын тоглолт, галын наадам зэрэг арга хэмжээг зохион байгуулсан болно.</p> <p>Энэ арга хэмжээний баримтжуулалт болох баримтат нэвтрүүлэг бэлэн болсон бөгөөд зурагт цомог, хурлын эмхэтгэлийг нэгтгэн ном гарын авлага бэлтгэхэд хамтран ажиллаж байна. <b>“eco women”</b> пэйж хуудаснаас үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.</p> <p><b>Тав.</b> Хүний эрхийн боловсролын чиглэлээр Комисс нь 2013-2017 онуудад Монголын Эмнести Интернэшнл хамтран “Хүний эрхийн боловсролыг хүн бүрт” нэгдүгээр, “Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын өнгөрсөн, одоо, ирээдүй” хоёрдугаар онол, практикийн бага хурал зохион байгуулж, Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн хэрэгжилтийг онол, практикийн түвшинд судалж, цаашид улам сайжруулах арга зам бүхий зөвлөмж гаргах зэргээр олон талт нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж ирсэн билээ. 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 70 жилийн ойн хүрээнд “Хүний эрхийн соёлыг бэхжүүлэх нь” сэдэвт симпозиумыг Монголын Эмнести Интернэшнл, ГХЯ, Монголын Хуульчдын холбоотой МУИС-ын Хууль зүйн сургуультай хамтран зохион байгуулах ажлын хэсэгт ажиллав. Энэ хүрээнд ХЭҮК-оос тавих суурь үндсэн илтгэлд оруулах ажлын хүрээнд албан болон насан туршийн боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын өнөөгийн нөхцөл байдлын зураглалыг судалж, гарган тус зураглалыг инфографикаар боловсруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн Комиссын даргын нээлтийн үгийг боловсруулсан байна. Энэхүү симпозиумд хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, боловсролын салбарын ажилтан, албан хаагч, багш, сурган хүмүүжүүлэгч, эмч, эмнэлгийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, бизнес эрхлэгч, хууль сахиулагчид, хуульчид, өмгөөлөгчид, хөдөө орон нутгийн төлөөлөл болсон нийт 120 гаруй хүн оролцож, хүний эрхийн боловсролыг олгож, түгээж буй тогтолцоо, механизмыг хэрхэн сайжруулах, хэрхэн хүртээмжтэй болгох асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлж, санал бодлоо солилцохын зэрэгцээ эрхээ мэддэг иргэдийг төлөвшүүлэх, хөгжүүлэх чиглэлээр санал санаачилга, шийдлийг гаргасан болно. (Албан болон насан туршийн боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын өнөөгийн нөхцөл байдлын зураглалын инфо графикийг CD хуулбарлав.)</p>
--	--	---

		<p><b>Зургаа.</b> Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал” батлагдсаны 70 жилийн ойд зориулан 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Хуульчдын Холбоо, Глоб Интэрнэшнл Төвтөй хамтран “Үг хэлэх эрх чөлөө: түүхэн ач холбогдол ба одоо үе” сэдэвт олон улсын симпозиум болон “Түгээмэд эрхийн төлөө!” олон улсын сайн санааны сонгодог урлагийн тоглолт зохион байгуулах ажлын хэсэгт ажиллан, зохион байгуулалт, сурталчилгааны үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэв. Тус симпозиумд Комиссын дарга илтгэл тавьж мөн бусад улс орны мэргэшсэн судлаач, эрдэмтэд үг хэлэх эрх чөлөөний түүхэн ач холбогдол ба одоо үед хэрхэн биеллээ олж байгаа талаар өргөн хүрээг хамарсан илтгэл тавив. Тус симпозиумд илтгэл тавьсан зочин илтгэгч нар сонгодог урлагаар хичээллэдэг бөгөөд Монголын хуульчид болон мэргэжлийн дуучид, Улсын филармоны найрал хөгжмийн уран бүтээлчидтэй хамтран сонгодог урлагын тоглолтыг тайзнаа эгшиглүүлэн, уран бүтээлээ толилуулсан нь хүний эрхийг урлаг соёлоор түгээн сурталчилж, таниулсан шинэлэг содон, сонирхолтой чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. Энэхүү арга хэмжээний үеэр байгаль экологийн чиглэлийн уран бүтээлчдийн бүтээлийг дэлгэн үзүүлж, үзэсгэлэн гаргаж, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах нь бидний үүрэг болохыг сурталчилсан болно. Үзэх холбоос: <a href="https://www.mglbar.mn/news/2768">https://www.mglbar.mn/news/2768</a></p> <p>2014 онд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний ойлголт, ач холбогдол, олон улсын хэм хэмжээ, чиг хандлага, хязгаарлах нөхцөл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба олон ургальч мэдээлэл, интернэт эрх чөлөө ба онлайн орчин зэрэг багц асуудлын хүрээнд сургагч багш нарт зориулсан сургалтын гарын авлага боловсруулж, сургалт сурталчилгааны үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна.</p> <p><b>Долоо.</b> Комисс нь Монголын Эмнести Интернэшнл, Монголын Хуульчдын Холбоо, Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль зүйн сургуультай хамтран Монгол Улсад орон байртай байх эрхийн хүрээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны хууль эрх зүйн орчныг хүний эрхийн суурь зарчим, хэм хэмжээнд нийцүүлэхэд чиглэлээр нөлөөллийн олон талт ажлуудыг хийж байгаа бөгөөд эдгээр байгууллагуудын хамтарсан ажлын хэсэгт 2015 оноос хойш ажиллаж байна. 2015 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр анх зохион байгуулсан “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” онол практикийн бага хуралд “Албадан нүүлгэлт ба төрийн оролцоо” сэдвээр илтгэл тавив. Илтгэлийг үзэх холбоос: <a href="https://amnesty.mn/~amnestym/index.php/book-library/155-resources/online-news/2018-12-30-08-36-21/541-2020-05-05-07-01-53">https://amnesty.mn/~amnestym/index.php/book-library/155-resources/online-news/2018-12-30-08-36-21/541-2020-05-05-07-01-53</a></p> <p>2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Хот дахин төлөвлөлт-Газар чөлөөлөлт-Хүний эрх” онол практикийн хурлыг зохион байгуулах ажлын хэсэг ажиллан бүхий л үйл ажиллагааны зохион байгуулалт, зохицуулалтыг хангасан болно. Онол практикийн хурлаас гаргасан зөвлөмжийг боловсруулах ажлыг Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, Ц.Алтанцэцэг, багш Р.Очирбал нартай хамтран гүйцэтгэж, уг зөвлөмжийг холбогдох талуудад хүргүүлэх ажлын зохион байгуулав. <a href="https://amnesty.mn/~amnestym/index.php/book-library/155-resources/online-news/2018-12-30-08-36-21/539-2020-05-05-06-51-43">https://amnesty.mn/~amnestym/index.php/book-library/155-resources/online-news/2018-12-30-08-36-21/539-2020-05-05-06-51-43</a></p> <p>2019 оны 5 дугаар сарын 8-ны өдөр “Хот дахин төлөвлөлт- Газар чөлөөлөлт-Хүний эрх”</p>
--	--	---

		<p>зөвлөлдөх уулзалтын бэлтгэл, зохион байгуулалтыг хариуцан ажиллаж, уулзалтад ирүүлсэн Ерөнхий сайдын илгээлт, Комиссын даргын хэлэх үгийг боловсруулж, миний бие “Төсөл хэрэгжүүлэгч талуудын бодитоор зөвлөлдөх, иргэдийн оролцоо, газар чөлөөлөлттэй холбоотой анхаарах асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв. Зөвлөлдөх уулзалтын үр дүнд гаргасан байр суурийн баримт бичгийг боловсруулах ажлыг хамтран гүйцэтгэв.</p> <p>Байр суурийн баримт бичгийг үзэх холбоос:  <a href="https://amnesty.mn/~amnestym/index.php/book-library/155-resources/online-news/2018-12-30-08-36-21/540-2020-05-05-06-58-05">https://amnesty.mn/~amnestym/index.php/book-library/155-resources/online-news/2018-12-30-08-36-21/540-2020-05-05-06-58-05</a></p> <p><b>Найм.</b> Комиссын бодлого үйл ажиллагааны түвшинд сонгох, сонгогдох эрх, ахмад настны эрхийн асуудлыг тус тус хариуцан ажилладаг билээ. 2012-2015 он хүртэл хугацаанд өдөр тутмын сонинд сонгох, сонгогдох эрхийн асуудлаар “Иргэн төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, “Сонгогчийн боловсролд”, “Хариуцлагатай сонголтоор бид эрхээ баталгаажуулна”, “Сонгуулийн үндсэн зарчим хүний эрхийн баталгаа болох нь”, “Сонгогч таны эрх” зэрэг сэдвээр нийт 7 удаагийн нийтлэл бичиж олон нийтийн хүртээл болгожээ. Мөн сонгох, сонгогдох эрхийн үндсэн ойлголтоор “Хүний эрх” эмхэтгэлд нийтлэл бэлтгэж, хэвлүүлсэн байна. 2015 онд Европын аюулгүй байдал ба хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газрын Сонгуулийн албанаас Серби Улсын нийслэл Белград хотноо зохион байгуулсан сонгуулийн урт хугацааны ажиглагчдын ээлжит 6 дахь онлайн болон танхимын сургалтад оролцож, сонгуулийн богино хугацааны ажиглагч, сонгуулийн урт хугацааны ажиглагчийн мандат авах эрхтэй болсон. 2012 оны Улсын Их Хурлын болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үеэр Мерси-Кор Монгол, “Хүртээмжтэй орчин 2012-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгуулийн тэгш оролцоо” аяны байгууллагуудтай хамтран Архангай, Өвөрхангай, Увс, Дархан, Дундговь, Баянхонгор аймаг, Нийслэлийн Сүхбаатар, Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн 101 хэсгийн хороодод ажиглалт, үнэлгээ хийж, тайланг нэгтгэн боловсруулав. Мөн цагдан хорих байр, баривчлах байр, цэргийн ангиудад сонгох эрхийн хэрэгжилтэд ажиглалт хийсэн байна. Сонгуулийн ерөнхий хороотой хамтран баривчлагдсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сонгогчдод зориулан зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөхтэй холбоотой асуудлаар эвхмэл хуудсыг боловсруулж тараах, иргэдийн сонгох эрх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй орчны асуудлыг хөндсөн тусгайлан хөндөж, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх 25 минутын нэвтрүүлгийг МҮОНТВ-тэй хамтран бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх, Youtube хуудаст байршуулсан байна. 2016 оны УИХ, аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үеэр санал авах байрыг хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод хүртээмжтэй байдлаар бэлтгэхэд анхаарах асуудлаар холобгдох саналаа гарган танилцуулж, Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэв. Мөн санал авах байрууд хөгжлийн бэрхшээлтэй сонгогч саналаа өгөх боломж, орчны хүртээмжийн байдалтай танилцах 20 санал авах байрны зохион байгуулалт стандартад нийцээгүй, зарим хэсэгт сонгогчид саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангагдаагүй зөрчилтэй байгааг газар дээр зөвлөж ажиллалаа. Мөн 2014 онд сонгох,</p>
--	--	--

		<p>сонгогдох эрхийн сургалтын модулийг боловсруулж, Комиссын сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд нэвтрүүлэв.</p> <p><b>Ес.</b> ХЭҮК нь МҮЭХ, МХЕГ, ХБНГУ-ын Фридрих Эбертийн Сангийн хамтын ажиллагааны хүрээнд 2014 оноос хойш “Хөдөлмөрлөх эрх” сэдэвт сургалтыг бүсчилсэн сургалтыг үйлдвэрчний эвлэлийн холбоодын идэвхтэн сонгуультнууд, ХЭҮК-ын орон нутаг дахь ажилтнууд, Мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн хяналт болон нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч нарт зохион байгуулж ирсэн. 2016-2019 оны хооронд 6 удаагийн бүсийн сургалтад сургагч багшаар ажиллан, сургалт бүрт 3 сэдвээр хичээл боловсруулж, сургалтыг оролцооны аргад тулгуурлан хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхтэй холбоотой кейс тохиолдлыг бэлтгэн, шинжлэн судлуулах, анализ дүгнэлт хийлгэх зэргээр 400 орчим оролцогчдод хүрч ажилласан байна.</p> <p>2018 онд МҮЭХ-ны Залуучуудын хороо ХБНГУ-ын Фридрих Эбертийн сантай хамтран зохион байгуулсан “ҮЭ-ийн залуу идэвхтэн, сонгуультны үндэсний Decent work foe youth-2018” чуулганд оролцож, МҮЭХ-ны залуучуудын хорооны гишүүн залуустай хийх панел хэлэлцүүлгийн илтгэгчээр ажиллаж, залуучуудын зохистой хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх эрх зөрчигдсөн тохиолдолд эрхээ хамгаалуулах, ямар төрлийн гомдол Комисст гаргах талаар болон Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхтэй холбоотой зохицуулалтууд хэрхэн тусгагдаж байгаа зэрэг олон асуудлаар санал солилцлоо.</p> <p>2019 оны 4 дүгээр сарын 9-10-ны өдрүүдэд ХБНГУ-ын Фридрих Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр МҮЭХ, УИХ-ын Нийгмийн бодлого, болосврол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, ХЭҮК, МХЕГ, хамтран “Хөдөлмөрлөх эрхийн өнөөгийн төлөв байдал-Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчлэл-Зохистой хөдөлмөр” сэдэвт Үндэсний чуулганаар Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бүлэг заалт бүрээр дэлгэрэнгүй хэлэлцэх хуулийн төсөлд холбогдох саналаа гаргах нэгтгэн саналаа гаргах панель хэлэлцүүлгийг чиглүүлэн ажиллаж, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсэгт хүргүүлэх 47 саналыг томъёоллыг боловсруулахад хамтран ажиллалаа.</p> <p>2013 оны 8, 9 сард ХЭҮК, МҮЭХ-той хамтран барилгын салбар дахь хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудлаар 15 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр Комиссын гишүүний шаардлага зөвлөмжийг боловсруулж, хүргүүлсэн болно. Мөн барилгын салбарын хурдацтай хөгжлийн өнөө үед тус салбарын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг зохих түвшинд хангахгүй байгаагаас хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхүүд ноцтой зөрчигдөж, хүний амь нас эрсдэж, үйлдвэрлэлийн ослын тоо өсөн нэмэгдэж байгаад судалж, дүн шинжилгээ хийн улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд барилгын салбарын оруулж буй хувь нэмэр ихэсч, үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд олноор бий болж байгаатай уялдуулан тус салбарт хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, журам, дүрэм, технологийн горимыг сахиулан мөрдүүлэх зорилгоор ОУХБ-ын Хөдөлмөрийн</p>
--	--	--



		<p>аюулгүй байдал, эрүүл ахуйг дэмжих суурь тогтолцооны тухай 2006 оны 187 дугаар конвенц болон Барилгын салбар дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1988 оны 167 дугаар конвенцыг тус тус соёрхон батлах санал, зөвлөмжийг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлд тусгав. Эдгээр конвенцод нэгдэн орох талаар Барилга хот байгуулалтын сайд, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүйн сайд, Хөдөлмөрийн сайд нарт санал хүргүүлэх зэргээр нөлөөллийн олон талт сургалт сурталчилгааны ажлуудыг хийж ирсэн билээ. Барилгын салбар дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 1988 оны 167 дугаар конвенцыг 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр соёрхон баталсан нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр удирдлагын манлайлал, менежментийн нэгдсэн бодлогоор хангаж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх хяналт, хариуцлагын нэгдсэн тогтолцоо бүрдэхэд ач холбогдолтой байх юм. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлийг үзэх холбоос: <a href="https://lib4u.net/opac.php/ebook/?id=19&amp;lib=nhrc">https://lib4u.net/opac.php/ebook/?id=19&amp;lib=nhrc</a></p> <p><b>Арав.</b> НҮБ-ын Хүүхдийн сангаас 2012 онд эрхлэн гаргасан “Хүүхдийн сайн сайхны төлөө шашны бүлгүүдтэй түншлэх нь” гарын авлагад хүүхдийн сайн сайхны төлөө, хүүхдийн эрхийг хангаж, хамгаалахад НҮБ-ын Хүүхдийн сангаас дэлхийн голлох шашны бүлгүүдтэй хэрхэн хамтарч ажилласан туршлага, практикийн талаар өгүүлсэн байдаг. Комисс нь 2012 онд шашны сургууль, сүм хийдэд шавилан суралцаж буй хүүхдийн эрхийн нөхцөл байдалд хийсэн хяналт, үнэлгээний хүрээнд шашны байгууллагуудад хүүхдийн эрхийн чиглэлээр ном гарын авлагын хэрэгцээ шаардлага их байгааг тодорхойлсон билээ. НҮБ-ын Хүүхдийн сангаас 2012 онд эрхлэн гаргасан “Хүүхдийн сайн сайхны төлөө шашны бүлгүүдтэй түншлэх нь” гарын авлагыг орчуулан хэвлүүлж, иргэд, олон нийтэд хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төр болон төрийн бус байгууллагууд, шашны бүлгүүдэд түгээн, сурталчлах нь хүүхдийн эрхийг хангаж, хамгаалахад хувь нэмрээ оруулах боломжтой гэж үзэн уг гарын авлагыг англи хэлнээс монгол хэл рүү орчуулах, хянах, төр болон төрийн бус байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа шашны бүлгүүдэд түгээн, иргэд олон нийтэд таниулан сурталчлах ажлын хүрээнд 2015 онд Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн санд жижиг төслийн саналыг боловсруулж хүргүүлэв. Төслийн санал дэмжигдсэний дагуу гарын авлагыг англи хэлнээс монгол хэлнээ орчуулсан орчуулгыг хянан тохиолдуулж, Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгчийн газрын “Ном хэвлэлд санал дүгнэлт өгөх комисс”-ын өгсөн зөвшөөрлийн дагуу хэвлүүлэв. 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүний эрхийн олон улсын өдрөөр Комиссын Хүний эрхийн цахим номын сангийн нээлтийн арга хэмжээнд “Хүүхдийн сайн сайхны төлөө шашны бүлгүүдтэй түншлэх нь” гарын авлагыг бусад шинээр гаргасан 3 номын хамт танилцуулж, сурталчилсан бөгөөд уг арга хэмжээнд 16 байгууллагын номын сангийн удирдлагууд оролцож, санал сэтгэгдлийн дэвтэрт тус гарын авлагыг маш их хэрэгтэй чухал ном гарсныг онцлон тэмдэглэсэн байв.</p> <p>“Хүүхдийн сайн сайхны төлөө шашны бүлгүүдтэй түншлэх нь” гарын авлагыг үзэх холбоос: <a href="https://lib4u.net/opac.php/ebook/?id=180&amp;lib=nhrc">https://lib4u.net/opac.php/ebook/?id=180&amp;lib=nhrc</a> гарын авлагыг CD хуулбарлав.</p>
12	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршлагын талаар	

	<p>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;</li> <li>-ажлын байрны тодорхойлолт;</li> <li>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;</li> <li>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл</li> </ul> <p><b>Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.</b></p>	
13	<p><b>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</b> Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.</li> <li>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ.</li> </ul>	Гишүүнчлэлгүй
14	<p><b>Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.</li> <li>-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг</li> </ul>	<p>Боловсруулсан, хянасан хэвлүүлсэн материалыг <b>Хавсралт: 4-д</b> жагсаалт үйлдэн хавсаргав.</p> <p>Байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, шаардлага, зөвлөмжийн талаар</p> <p><b>Хавсралт: 1, 2-д</b> Хуулийн төсөл болон хууль тогтоомжийн төсөл дүрэм журмын төсөлд өгсөн саналын томъёолол, батлагдсан хуулиудад Комиссын санал тусгагдсан эсэхэд хийсэн дүн шинжилгээний мэдээг жагсаалт үйлдэн хавсаргав.</p> <p><b>Хавсралт: 3-д</b> Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг боловсруулсан байдлыг жагсаалт үйлдэн хавсаргав.</p>

<p>хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.</p> <p>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.</p> <p>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.</p> <p><b>Жич:</b> Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана.</p>	<p><b>Хавсралт: 9-д</b> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл боловсруулахад оролцсон жагсаалт үйлдэн хавсаргав.</p> <p>Хүний эрхийн сургалт лекцийн мэдээллийг <b>Хавсралт: 5-д</b> жагсаалт үйлдэн хавсаргав.</p> <p>Өөрийн тавьсан илтгэлийг <b>Хавсралт: 8-д</b> жагсаалт үйлдэн хавсаргав.</p> <p>Удирдлагын нээлтийн үг, илтгэл, мэндчилгээ, ярилцлагыг <b>Хавсралт:7-д</b> жагсаалт үйлдэн хавсаргав.</p> <p>Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг <b>Хавсралт: 6-д</b> жагсаалт үйлдэн хавсаргав.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Комисс нь олон улс, бүс нутгийн болон үндэсний хэмжээнд төр, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааны хүрээнд Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан тогтвортой хамтран ажиллаж ирсэн бөгөөд энэ хүрээнд 2011-2013 онд Цагдаагийн Ерөнхий Газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичгийг боловсруулсан бөгөөд эдгээр байгууллагуудтай 2 жилийн хугацаанд хамтын ажиллагааны чиглэлээ тогтон хамтран ажиллаж ирсэн байна.</li> <li>- Жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдөр буюу хүний эрхийн олон улсын өдрийг угтсан кампанит сурталчилгааны ажилд ажил үүргийн хуваарийн дагуу оролцож ирсэн. “Хүний эрхийн нээлттэй” өдөр арга хэмжээний хүрээнд 21 аймагт хүрч ажиллажээ.</li> <li>- Комиссын хяналт шалгалт, судалгаа, шинжилгээний ажлуудын удирдамж, хэрэглэгдэхүүнийг боловсруулах, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлээр хүргүүлсэн санал зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, тухайн асуудлыг шийдвэрлүүлэхээр эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх зэргээр бодлогын дүн шинжилгээг хийж ирлээ. Мөн АТГ, Ази номхон далайн бүс нутгийн ХЭҮБ-ын чуулганд Комиссын үйл ажиллагааны тайланг хүргүүлэх, дотооддоо мөрдөгдөж хөтөлбөрийн үнэлгээг хийх, Комиссын шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх зэрэг ажлыг хийжээ.</li> <li>- Ерөнхийлөгчийн 2018 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 5 дугаар зарлигаар “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах танилцуулах мэдээг улирал тутмын мэдээг ҮАБЗ-д, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 6 дахь удаагийн ээлжит тайланд НҮБ-ын Хүний эрхийн хорооноос өгсөн зөвлөмжүүдийг 2018-2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасан Комисст хамаарал бүхий ажлын тайланг бэлтгэж, ХЗДХЯ-д тогтмол хүргүүлж байна.</li> <li>- 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдөр “Монгол Улс дахь уул уурхайн бизнес ба хүний эрх” олон улсын бага хуралд оролцогч, гадаад дотоодын зочид төлөөлөгчдөд зориулсан арга хэмжээ болон 2015 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Ази Номхон Далайн Бүс Нутгийн ХЭҮБ-уудын чуулганы 20 дахь удаагийн уулзалтад оролцогч, гадаад, дотоодын зочид төлөөлөгчдөд зориулсан арга хэмжээ болон хүний эрхийн</li> </ul>
--	---

		<p>асуудлаар зохион байгуулсан онол практикийн хурал, зөвлөгөөн, чуулганы хөтөлбөр хэрэглэгдэхүүнийг боловсруулах, техник зохион байгуулалтыг хариуцах зэргээр ажиллаж ирсэн.</p> <ul style="list-style-type: none"><li>- Үндэсний статистикийн хороо, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, зарим яамдын дэргэд байгуулагдсан хэд хэдэн ажлын хэсэгт ажилласан байна.</li><li>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2007, 2008, 2009 онд зохион байгуулсан 1000 оролцогчтой үндэсний чуулганыг зохион байгуулахад ажил үүргийн хуваарийн дагуу оролцож, чуулганаас гарсан зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд ажлын хэсэг байгуулагдан, түүний нарийн бичгийн даргаар 3 жил ажиллан зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, үнэлэх зэрэг ажлуудыг хийсэн байна.</li></ul>
--	--	---

--- оОо ---